



БАЯНХОНГОР АЙМАГ
БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/146

Хориулт

Хог хаягдлын цэвэрлэгээний
газрын зааг тогтоох, хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг хариуцан цэвэрлэх нийтийн эдэлбэр газрын заагийг 1 дүгээр, нийтийн эдэлбэр газар, орчны цэвэрлэгээ хийх хуваарийг 2 дугаар, хөдөөгийн багуудын цэвэрлэгээний хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сумын төвийн аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хилийн нийтийн эдэлбэр газрыг заагдсан хугацаанд бүрэн цэвэрлэн, иргэдийн эрүүл орчинд амьдрах таатай орчин бүрдүүлэхэд хамтран ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт, хуваарьт газрыг тогтоосон хугацаанд цэвэрлэгээ хийж байгаа байдалд хяналт тавьж ажиллахыг Хориулт 6 дугаар багийн Засаг дарга (А.Цолмон), байгаль хамгаалагч (Г.Бат-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Хөдөөгийн багийн нутаг дэвсгэрийн орчны, нийтийн эзэмшил газрын цэвэрлэгээг тогтоосон хугацаанд цэвэрлүүлэх арга хэмжээ авч хяналт тавьж ажиллахыг багуудын Засаг дарга нар (Д.Цэрэнжигмэд, Ц.Анхбаяр, Ц.Цэвэлмаа, Т.Өнөржаргал, П.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцсан нутаг орчны цэвэрлэгээг тогтоосон цаг хугацаанд нь хийгээгүй аж ахуйн нэгж, байгууллагын дарга, багийн Засаг дарга нарт хариуцлага тооцох, хог хаягдлын цэвэрлэгээний тайланг улирлаар авч архивын нэгж үүсгэн сумын Засаг дарга, холбогдох удирдах ажилтнуудад тайлагнаж байхыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Ганзориг)-д даалгасугай.



642201312


Богд сумын Засаг даргын 1023 оны 01 дүгээр
сарын 14-ны өдрийн 1/16 дугаар захирамжийн
01 дүгээр хавсралт



НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ЦЭВЭРЛЭГЭЭГ
АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД
ХУВААРИЛСАН ХУВААРЬ

- **Бүрэн дунд сургууль:** Биеийн тамирын талбай, байгууллагаас хуучин хогийн цэг хүртэлх газар
- **Цэцэрлэг:** Татуурын булгын эхээс Соёлын төв хүртэлх голын ай сав газар, Түйн гол хүртэлх газрыг давхар хариуцна.
- **Соёлын төв, Засаг Даргын Тамгын газар:** Соёлын төвийн харалдаагаас Маагийн толгой, доод гарам хүртэлх газар голын 2 талыг давхар хариуцна.
- **Эрүүл мэндийн төв:** Байгууллагаас Суварга хүртэл, Суваргаас цааш машин зам хүртэлх газар
- **Цаг уур, Газар хөдлөлтийг бүртгэх Богд станц, Банкууд:** Голын доод гармаас Морь барьдаг хүртэлх газар
- **Шатахуун түгээх станцууд:** Суваргаас түүхий эдийн цэг хүртэлх газар
- **Бизнес эрхлэгчид:** Дэлгүүрүүдээс Цагдаагийн кабон, Халуун ус хүртэл хуучин Соёлын төвийг тойрсон газар
- **Ахмадууд:** Ахмадын байрнаас тойроод сүүдрэвчтэй толгой хүртэлх газар


Богд сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 1/16 дугаар захирамжийн 02 дугаар хавсралт



НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ХУВААРЬ

№	Нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээ	Орчны цэвэрлэгээ	Цэвэрлэгээ хийх цаг	Тайлбар
1	2	3	4	5
1	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн сарын бүрийн долоо хоногийн 4 дэх өдөр хийгдэнэ	Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд 2, 4 дүгээр долоо хоногийн 4 дэх өдөр хийгдэнэ	15 ⁰⁰ -16 ⁰⁰	Цэвэрлэгээ хийгдэх 4 дэх өдөр олон нийтийн баяр, амралтын өдөр, байгалийн цаг агаарын хүндрэлтэй байвал 2, 3 дэх өдөр хийгдэнэ.

Богд сумын Засаг даргын 2003 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 146 дугаар захирамжийн 02 дугаар хавсралт



ХӨДӨӨГИЙН БАГУУДЫН НИЙТИЙН ЭДЭЛБЭР
ГАЗАР, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ХУВААРЬ

№	Нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээ	Орчны цэвэрлэгээ	Цэвэрлэгээ хийх цаг	Тайлбар
1	2	3	4	5
1	Хөдөөгийн малчин айл өрхүүд улирлын сүүлийн сарын сүүлийн долоо хоногийн 4 дэх өдөр хийгдэнэ	Хөдөөгийн малчин айл өрх нь сар бүрийн сүүлийн долоо хоногийн 4 дэх өдөр хийгдэнэ	15 ⁰⁰ -16 ⁰⁰	Цэвэрлэгээ хийгдэх 4 дэх өдөр олон нийтийн баяр, амралтын өдөр, байгалийн цаг агаарын хүндрэлтэй байвал 2, 3 дэх өдөр хийгдэнэ.